АКПАР АУДИТ ХХК

“ГРИЙН КАРБОН КАПИТАЛ” ББСБ

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЫГ ДУУСГАВАР БОЛГОСОН ТУХАЙ ТАЙЛАН

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

“Акпар-Аудит” *компанийн:*

Партнер
Х.Баянбай

Аудитор
С.Нарангэрэл

Чанарын хяналтын менежер
Э.Нармандах

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 91919758 дугаарын утсаар харилцана уу

ХАЯГ:
Баянзүрх дүүрэг, 3-р хороо,
Токиогийн гудамж 45а,
Оршил төвийн 7 давхар 701 тоот

Утас:91919758

E-mail: ***akpar.audit@gmail.com***

АГУУЛГА: ***хуудас***

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын дүгнэлт	2
Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	4
Байгууллагын талаархи мэдээлэл	4
Материаллаг байдлын түвшин	4
Тасралтгүй үйл ажиллагааны талаарх мэдээлэл	4
Балансын дараах үйл явдал	4
Аудит хийгдсэн Санхүүгийн байдлын тайлан	5
Аудит хийгдсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	6
Аудит хийгдсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	6
Аудит хийгдсэн Мөнгөн гүйлгээний тайлан	7

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Нягтлан бодох бүртгэлийн талаарх мэдээлэл	8
Санхүүгийн тайлангийн талаарх мэдээлэл	9
Мөнгөн хөрөнгө	9
Зээл	9
Авлага	9
Бусад хөрөнгө	9
Үндсэн хөрөнгө	10
Үндсэн хөрөнгийн элэгдэл	10
Биет бус хөрөнгө	10
Бусад өр төлбөр	10
Хүүгийн орлого	10
Хүүгийн бус орлого	10
Хүүгийн бус зардал	10

Улаанбаатар хот **2026 оны 3-р сар**

“ГРИЙН КАРБОН КАПИТАЛ” БАНК БУС
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН
УДИРДЛАГАД

Хараат бус аудиторын тайлан

Бид Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн холбогдох заалтуудыг үндэслэн “Грийн карбон капитал” ББСБ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон Санхүүгийн байдлын тайлан (баланс), Орлого үр дүнгийн тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан буюу тайлангийн тодруулгуудаас бүрдсэн жилийн эцсийн Санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар “Грийн карбон капитал” ББСБ-ын 2025 оны 12 дугаар сарын 31- ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. АОУС-д заасан аудиторын хүлээх үүрэг, хариуцлагыг “Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага” гэсэн хэсэгт тусгаж харуулав. Аудитын ажилд хамааралтай хараат бус байдлын болон ёс зүйн шаардлагуудыг бүрэн биелүүлж ажилласан. Бидний олж авсан баримт нотолгоонууд дээрх дүгнэлтийг гаргахад хангалттай, тохиромжтой гэж үзэж байна.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлангаа СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан заавар журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, хуульд нийцүүлэн боловсруулан, тогтмол мөрдөж ажиллах нь тухайн байгууллагын удирдлагын үүрэг болно.

Мөн түүнчлэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хөрөнгийг янз бүрийн зальт ажиллагаанд өртүүлэхгүй байхаар дотоод хяналтын системийг бий болгох, байгууллагын үйл ажиллагааны болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурь, зарчмыг хангаж ажиллах нь байгууллагын удирдлагын хариуцлага юм.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага

Аудиторын гол зорилго нь үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангийн улмаас материаллаг буруу илэрхийллээс ангид эсэхэд дүгнэлт өгөхөд оршино. Тодорхой дүгнэлтэд хүрэхийн тулд АОУС-д нийцүүлэн боловсруулсан горимын дагуу шалгалт хийж, хангалттай, тохиромжтой баримт нотолгоо цуглуулах нь аудиторын үүрэг юм.

Аудитын горимуудыг батлагдсан төлөвлөгөөний дагуу аудитор өөрийн шийдлээр сонгох ба ирүүлсэн алдаа, зөрчил нь материаллаг буюу байгууллагын удирдлага болон хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх эсэхэд дүн шинжилгээ хийж, түүнд тохирсон дүгнэлт өгнө.

Аудитын шалгалтаар байнга алдаа зөрчил илрэх ёстой гэсэн ойлголт байж болохгүй бөгөөд бидний илрүүлсэн алдаа, зөрчил материаллаг бус бол түүнийг арилгуулах талаар тодорхой зөвлөгөө өгч ажиллана.

Цаасан болон цахим хэлбэрээр бэлтгэсэн аудитын ажлын баримтууд нь тус компанийн өмч бөгөөд аудиторын тайлан, зөвлөмжийн хамт 10 жил хадгална.

УЛААНБААТАР ХОТ

Х.БАЯНБАЙ

ПАРТНЕР

АКПАР АУДИТ ХХК

9022120175 5229979

2026-03-12

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Харилцан тохиролцож байгуулсан гэрээний дагуу “Грийн карбон капитал” ББСБ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг “Аудитын тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Банк бус санхүүгийн байгууллагын тухай” хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн боловсруулсан дотоод горимын дагуу гүйцэтгэв.

Байгууллагын талаарх мэдээлэл

1	Байгууллагын нэр	"Грийн карбон капитал" ББСБ
2	Регистрийн дугаар	4296044
3	Байгуулагдсан он	2025.02.01
4	Хувьцаа эзэмшигчдийн нэр	Монгол улсын иргэн П.Сайнбилэг, Л.Ариунболд, А.Энхгэрэл
5	Эцсийн өмчлөгчийн нэр	Л.Ариунболд
6	Үйл ажиллагааны чиглэл	Зээл олгох
7	Хаяг байршил	Дархан-Уул, Дархан, 13-р баг, Эмэгтэйчүүдийн ордон түрээс

Материаллаг байдлын түвшин

Материаллаг байдлын түвшинг тэвчиж болох хамгийн багаар буюу нийт зардлын 2.0 хувиар тогтооход 1.2 сая төгрөг байна.

Тасралтгүй үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад нөлөөлөх, эргэлзээ төрүүлэх нөхцөл байдал ажиглагдаагүй.

Балансын дараах үйл явдал

Санхүүгийн тайлант жил дууссанаас эхлэн аудитын тайлан, дүгнэлт гаргах хүртэлх хугацаанд анхаарал татахуйц онцгой зүйл тохиолдоогүй байна.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(төгрөгөөр)

БАЛАНСЫН ЗҮЙЛ	2024 он	2025 он
ХӨРӨНГӨ		
А.Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	149,705,885.82	114,467,601.26
Богино хугацаат хөрөнгө оруулалт	-	-
Зээл	387,778,268.48	681,907,627.44
Авлага	3,023,736.88	7,844,183.16
Бусад хөрөнгө	50,000,000.00	91,268,551.00
Эргэлтийн хөрөнгийн дүн	**590,507,891.18**	**895,487,962.86**
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	600,000.00	600,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(30,394.30)	(90,361.45)
Биет бус хөрөнгө	11,016,854.00	11,016,854.00
Хуримтлагдсан элэгдэл	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	**11,586,459.70**	**11,526,492.55**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**602,094,350.88**	**907,014,455.41**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
Б.Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр	-	-
Бусад эх үүсвэр	-	-
Бусад өр төлбөр	2,059,568.81	2,004,946.93
Богино хугацаат өр төлбөрийн дүн	**2,059,568.81**	**2,004,946.93**
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөр	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	**-**	**-**
Өр төлбөрийн нийт дүн	**2,059,568.81**	**2,004,946.93**
Өөрийн хөрөнгө		
Энгийн хувьцаа	600,000,000.00	900,000,000.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	34,782.07	5,009,508.48
Нөөцийн сан	-	-
Эзэмшигчдийн өмчийн дүн	**600,034,782.07**	**905,009,508.48**
ӨР ТӨЛБӨР, ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	**602,094,350.88**	**907,014,455.41**

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2024 он	2025 он
Зээлийн хүүгийн орлого	51,665,242.28	66,825,051.94
Хүүгийн зардал	-	-
Цэвэр хүүгийн орлого	**51,665,242.28**	**66,825,051.94**
Хүүгийн бус орлого	6,928,175.00	1,060,077.12
Хүүгийн бус зардал	58,554,770.54	62,823,930.15
Цэвэр хүүгийн бус орлого	**(51,626,595.54)**	**(61,763,853.03)**
Болзошгүй эрсдэлийн сангийн зардал	-	-
Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	**38,646.74**	**5,061,198.91**
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	-
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	-	-
Ердийн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	**38,646.74**	**5,061,198.91**
Ердийн бус орлого	-	-
Ердийн бус зарлага	-	-
Татвар төлөхийн өмнөх цэвэр орлого	**38,646.74**	**5,061,198.91**
Орлогын татварын зардал	3,864.67	86,472.50
Татварын дараах цэвэр ашиг	**34,782.07**	**4,974,726.41**

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Хувьцаат капитал	Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	Нийт дүн
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**600,000,000.00**	**34,782.07**	**600,034,782.07**
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга			-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			-
Өмчид гарсан өөрчлөлт	300,000,000.00		300,000,000.00
Ногдол ашиг			-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-
Тайлант оны ашиг, (алдагдал)		4,974,726.41	4,974,726.41
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**900,000,000.00**	**5,009,508.48**	**905,009,508.48**

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2024 он	2025 он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	**678,052,516.06**	**457,669,498.62**
Зээлийн хүүгийн орлого	633,329,641.06	455,669,143.59
Бусад үйлчилгээний орлого	44,722,875.00	2,000,355.03
Мөнгөн зарлагын дүн	**1,128,346,630.24**	**792,907,783.18**
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	775,683,900.00	730,000,000.00
Төслийн зээлийн санхүүжилтийн хүүгийн зардал	-	-
Өрийн бичгийн хүүд төлсөн мөнгө	-	-
Хүүгийн зардлын буцаалт	-	-
Үндсэн ба нэмэгдэл цалин	58,736,367.00	18,280,000.00
Ажилтнуудад олгосон нөхөн олговор, тэтгэмж	-	-
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	-	-
Албан томилолт, сургалтын зардал	-	-
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	2,984,478.64	-
Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгслийн зардал	-	-
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	-	-
Татвар, даатгалын төлсөн мөнгө	-	-
Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	-	-
Үнэт цаасны авлагыг барагдуулах зардал	-	-
Зээлийн авлагыг барагдуулах зардал	-	-
Факторингийн авлагыг барагдуулах зардал	-	-
Итгэлцлийн үйлчилгээтэй холбоотой зардал	-	-
Санхүүгийн түрээсийн үйл ажиллагааны зардал	-	-
Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө	-	-
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	290,941,884.60	44,627,783.18
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(450,294,114.18)**	**(335,238,284.56)**
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	**-**	**300,000,000.00**
Үндсэн ба хөрөнгө борлуулсны орлого	-	-
Ногдол ашгийн орлого	-	-
Хандив	-	-
Бусад	-	300,000,000.00
Мөнгөн зарлагын дүн	**-**	**-**
Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал	-	-
Торгуулийн зардал	-	-
Бусад	-	-
Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**-**	**300,000,000.00**
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**(450,294,114.18)**	**(35,238,284.56)**
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	**600,000,000.00**	**149,705,885.82**
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**149,705,885.82**	**114,467,601.26**

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

I. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Мөнгөн хөрөнгө

Капитрон банканд төгрөгийн харилцах данстай.
Түргэн борлогдох үнэт цаас зэрэг мөнгөн хөрөнгөтэй адилтгах бусад хөрөнгө байхгүй байна.

Зээл

Зээлийн үлдэгдлийг зээлийн чанараар нь ангилж бүртгэсэн байна. Төлөгдөөгүй зээлийн 3.2 хувь нь хугацаа хэтэрсэн зээл байна.

Авлага

Тус дансанд хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлагыг бүртгэсэн байна.

Бусад хөрөнгө

Тус дансанд урьдчилж төлсөн зардлыг бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө болон түүний хуримтлагдсан элэгдэл

Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай тавилга эд хогшилыг бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг хөрөнгийн ашиглах хугацааг үндэслэн шулуун шугамын аргаар байгуулсан байна.

Биет бус хөрөнгө болон түүний хуримтлагдсан хорогдол

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай санхүүгийн програм хангамжийг бүртгэсэн байна.

Бусад өр төлбөр

Бусад өр төлбөрөөр аж ахуйн нэгжийн орлогын албан татварын өглөг, бусад татварын өглөг, урьдчилж орсон орлого болон бусад өр төлбөрийг бүртгэсэн байна.

Өөрийн хөрөнгө

Тус ББСБ нь тайлант хугацаанд 900.0 сая төгрөгийн дүрмийн сантай, тайлант онд 4.9 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Үйл ажиллагааны орлого

Үйл ажиллагааны үндсэн орлого нь зээлийн хүүгийн орлого, үйлчилгээний хураамжийн орлогоос бүрдсэн байна.

Үйл ажиллагааны зардал
Үйл ажиллагааны зардал нь ерөнхий удирдлагын зардал болон эрсдэлийн сангийн зардлуудаас бүрдсэн байна.

II. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Санхүүгийн тайлангууд нь Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан нягтлан бодох бүртгэлийн заавар, журам болон Монгол улсад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмуудтай мөн нийцэж байна.

Санхүүгийн тайлангуудыг нягтлан бодох бүртгэлийн түүхэн өртгийн суурьд үндэслэн, Монгол улсын мөнгөний нэгж болох төгрөгөөр илэрхийлсэн.

Санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгө болон түүний эх үүсвэрийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө

ҮЗҮҮЛЭЛТ	Валютын төрөл	2024 он	2025 он
Бэлэн мөнгө			
Мөнгөн касс	**MNT**	104,300,000.00	104,300,000.00
Бэлэн мөнгөний дүн		**104,300,000.00**	**104,300,000.00**
Харилцах дансанд дахь мөнгө			
Капитрон банк	**MNT**	500,000.00	8,619,819.53
Капитрон банк	**MNT**	44,886,285.82	1,529,381.73
Капитрон банк	**MNT**	19,600.00	18,400.00
Банкин дахь мөнгөний дүн		**45,405,885.82**	**10,167,601.26**
Нийт мөнгөн хөрөнгийн дүн		**149,705,885.82**	**114,467,601.26**

Зээл

ҮЗҮҮЛЭЛТ	2024 он	2025 он
Хэвийн зээл	387,778,268.48	659,931,751.14
Хугацаа хэтэрсэн зээл	-	21,975,876.30
Зээлийн нийт дүн	**387,778,268.48**	**681,907,627.44**

Авлага

ҮЗҮҮЛЭЛТ	2024 он	2025 он
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	3,023,736.88	7,844,183.16
Авлагын нийт дүн	**3,023,736.88**	**7,844,183.16**

Бусад хөрөнгө

ҮЗҮҮЛЭЛТ	2024 он	2025 он
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	50,000,000.00	91,268,551.00
Бусад хөрөнгийн дүн	**50,000,000.00**	**91,268,551.00**

Үндсэн хөрөнгө

Хөрөнгийн ангилал	Оны эхний үлдэгдэл	Өөрчлөлт		Оны эцсийн үлдэгдэл
		нэмэгдсэн	хасагдсан	
Тавилга эд хогшил	600,000.00	-	-	600,000.00
Үндсэн хөрөнгийн дүн	**600,000.00**	**-**	**-**	**600,000.00**

Үндсэн хөрөнгийн элэгдэл

Хөрөнгийн ангилал	Оны эхний үлдэгдэл	Өөрчлөлт		Оны эцсийн үлдэгдэл
		нэмэгдсэн	хасагдсан	
Тавилга эд хогшил	30,394.30	59,967.15	-	90,361.45
Үндсэн хөрөнгийн элэгдлийн дүн	**30,394.30**	**59,967.15**	**-**	**90,361.45**
Үлдэгдэл өртөг	**569,605.70**			**509,638.55**

Биет бус хөрөнгө

Хөрөнгийн ангилал	Оны эхний үлдэгдэл	Өөрчлөлт		Оны эцсийн үлдэгдэл
		нэмэгдсэн	хасагдсан	
Програм хангамж	11,016,854.00	-	-	11,016,854.00
Биет бус хөрөнгийн дүн	**11,016,854.00**	**-**	**-**	**11,016,854.00**

Бусад өр төлбөр

ҮЗҮҮЛЭЛТ	2024 он	2025 он
ААНОАТ-ын өглөг	3,864.67	-
ХХОАТ-ын өглөг	796,500.00	743,016.99
Бусад өглөг	1,259,204.14	1,261,929.94
Бусад өр төлбөрийн дүн	**2,059,568.81**	**2,004,946.93**

2025 оны орлого болон зардал нь дараах байдалтай байна.

Хүүгийн орлого

ҮЗҮҮЛЭЛТ	2024 он	2025 он
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	43,704,191.31	66,825,051.94
Харилцах дансны хүүгийн орлого	7,961,050.97	-
Зээлийн хүүгийн орлогын дүн	**51,665,242.28**	**66,825,051.94**

Хүүгийн бус орлого

ҮЗҮҮЛЭЛТ	2024 он	2025 он
Санхүүгийн үйлчилгээний шимтгэл	6,928,175.00	1,060,077.12
Хүүгийн бус орлогын дүн	**6,928,175.00**	**1,060,077.12**

Хүүгийн бус зардал

ҮЗҮҮЛЭЛТ	2024 он	2025 он
Үндсэн болон нэмэгдэл цалин	48,596,927.00	36,000,000.00
Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	5,210,418.92	4,500,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	30,394.30	59,967.15
Харилцаа холбоо, интернетийн зардал	252,000.00	-
Автоматжуулалттай холбоотой урсгал зардал	3,200,000.00	-
Бичиг хэргийн зардал	15,000.00	-
Бусад	1,250,030.32	22,263,963.00
Хүүгийн бус зардлын дүн	**58,554,770.54**	**62,823,930.15**